



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын
хөтөлбөр

Индекс: D031103

Шинжээчийн баг:

Ахлагч: Ч.Наранчимэг

Гишүүд: М.Должин

М.Банзрагч

Улаанбаатар хот

2021 оны 6 сарын 15-ны өдөр

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

АНУ	- Америкийн Нэгдсэн Улс
БНУУ	- Бүгд Найрамдах Унгар Улс
БНХАУ	- Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУЯ	- Боловсрол соёл шинжлэх ухааны яам
БШУС	- Боловсрол, шинжлэх ухааны сайд
ОХУ	- Оросын Холбооны Улс
ӨҮТ	- Өөрийн үнэлгээний тайлан
СБЗА	- Сургалтын бодлого зохицуулалтын алба
СЭЗИС	- Санхүү Эдийн Засгийн Их сургууль
ҮСХ	- Үндэсний статистикийн хороо
ХААИС	- Хөдөө Аж Ахуйн Их сургууль
ХААДС	- Хөдөө аж ахуйн дээд сургууль
ХНХЯ	- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХНХСИ	- Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын судалгааны институт
ХМСТ	- Хэрэглээний математик, статистикийн тэнхим
ШУТИС	- Шинжлэх ухаан техникийн их сургууль
ЭЗБС	- Эдийн засаг бизнесийн сургууль
ЭЕШ	- Элсэлтийн ерөнхий шалгалт
	-
ACBSP	- Accreditation Council for Business School Programs
CDIO	- Conceive Design Implement Operate
CLO	- Course Learning Outcome
PLO	- Program Learning Outcome
PEST	- Politic Economic Social Technology
PDCA	- Plan Do Check Act
DMAIC	- Define Measure Analyze Improve Control

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ХААИС, Эдийн засаг, бизнесийн сургууль University of Life Sciences, School of Economics and Business	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Эдийн засаг, статистик Economics, statistics	
Индекс	D031103	
Шинжээчид	Шинжээчийн багийн ахлагч: 1. Ч.Наранчимэг (СЭЗИС-ийн ХМСТ-ийн профессор, доктор /PhD/) Шинжээчийн багийн гишүүд: 2. М.Должин (Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургуулийн захирал, доктор /PhD/, профессор) 3. М.Банзрагч (ШУТИС-ийн Бизнесийн ахисан түвшний сургуулийн сургалт эрхэлсэн дэд захирал, доктор /PhD/, дэд профессор)	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбилэг	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	05/28-31	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	06/03	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/7,8	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	06/15	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/17	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	06/19	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	06/20	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ХААИС нь Монгол улсад “Эдийн засаг, статистик” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн анхны сургуулиудын нэг бөгөөд тус мэргэжлээр 1992-1998 онд бакалаврын эчнээ сургалтаар 3 удаа төгсөлт хийж нийтдээ 101 мэргэжилтэн, 2001 оноос БСШУЯ-ны тусгай зөвшөөрлийн дагуу тус мэргэжлээр бакалавр, магистр, докторын сургалт явуулах эрхтэй болж, улмаар өдгөө 500 гаруй мэргэжилтэн бэлтгэж гаргасан байна. Өнгөрсөн хугацаанд зах зээлийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэж, хөтөлбөрийн шинэчлэлийг тасралтгүй хийж ирсэн ба 2014 онд олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага ACBSP-ээр 2024 он хүртэл магадлан итгэмжлүүлж, 2014-2019 онуудад элсэгч болон төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг АНУ-ын Перегрины Академиар үнэлүүлсэн байна. Улмаар “Эдийн засаг, бизнес, хөдөө аж ахуйн болон нийгмийн олон талт асуудлаар мэдээллийн технологи ашиглан статистик мэдээллийг боловсруулах, дүн шинжилгээ хийх онол, судалгааны арга зүйг бүрэн эзэмшсэн хөрвөр чадвар бүхий мэргэжилтэн, судлаач бэлтгэхэд оршино” гэсэн зорилгын хүрээнд “Эдийн засаг, статистик” хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэх бакалаврын сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч үндсэн нэгж нь анх 1969 онд ХААДС-ийн ректорын 189 тоот тушаалаар байгуулагдсан Статистикийн тэнхимээс үүсэлтэй, олон жилийн түүхэн үе шатыг дамжсан Статистик, Эконометрикийн тэнхим юм. Тус тэнхим нь ХААИС-ийн бүтэц зохион байгуулалт болон Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд “Эдийн засаг, статистик” мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчилсэн /ХААИС-ийн захирлын 2017 оны 8 сарын 25-ны өдрийн А/183 тоот тушаалын хавсралтаар батлагдсан шинэчилсэн хөтөлбөр/ ба энэ нь одоо мөрдөгдөж буй БШУС-ын А/174 тушаалаар баталсан “Дээд боловсролын бакалаврын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” болон ХААИС-ийн сургалтын журамтай нийцэж байна. Эдүгээ тус хөтөлбөрөөр 2016-2020 онуудад буюу сүүлийн 5 хичээлийн жилд 182 оюутан, энэ хичээлийн жил 41 оюутан, нийтдээ 2016 оноос хойш 220 гаруй оюутан суралцаж, төгссөн байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ХНХЯ, ХНХСИ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа -2002” тайлан
- “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2019” тайлан
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны сэлтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичгүүд
- ХААИС-ийг 2019-2028 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- ХААИС-ийн дүрэм
- ХААИС-ийн ЭЗБС-ийн стартеги төлөвлөгөө
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын хандлага, хэрэгцээ шаардлагыг судалсан.
- Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн динамикийг гарган, эрэлтийг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн үндэслэл, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг харьцуулсан нь ач холбогдолтой болсон байна.
- Цалингийн судалгаа, байгууллагаас чухалчилдаг ур чадвар, PEST шинжилгээ, ажлын байрны эрэлт хэрэгцээ, төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал, хөтөлбөрийн бүтцийн харьцуулалт зэргийг өргөн хүрээнд хийсэн нь хөтөлбөр хэрэгцээ шаардлагатай болохыг харуулж чадсан байна.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- Худалдаа үйлдвэрлэлийн их сургуулийн эдийн засгийн математик загварчлал мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулалт хийх шаардлагатай.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ХНХЯ, ХНХСИ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа -2002” тайлан
- “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2019” тайлан
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны сэлтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичгүүд
- ХААИС-ийг 2019-2028 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- ХААИС-ийн дүрэм
- ХААИС-ийн ЭЗБС-ийн стартеги төлөвлөгөө
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн стратеги төлөвлөгөө болон оролцогч талуудын саналыг тусган хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон.
- Хөтөлбөрийн зорилт, өнөөгийн түвшин, хүрэх үр дүнг харьцуулан хүснэгтээр харуулсан нь хөтөлбөрийн зорилготой танилцахад хялбар байсан.
- ХААИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн, хөтөлбөрийн зорилгыг харьцуулсан, зорилт бүрээр дүгнэсэн.
- Хөтөлбөрийн зорилгыг оролцогч талуудын оролцоотой, судалгаанд тулгуурлан тогтоосон.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ХНХЯ, ХНХСИ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа -2002” тайлан

- “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа-2019” тайлан
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Оюутны сэлтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичгүүд
- ХААИС-ийг 2019-2028 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө
- ХААИС-ийн дүрэм
- ХААИС-ийн ЭЗБС-ийн стартеги төлөвлөгөө
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрөөр олгох мэдлэг ур чадварыг ерөнхий мэдлэг, мэргэжлийн ерөнхий, мэргэшүүлэх хэмээн хуваан ялгаатай томъёолсон.
- Олон улсад магадлан итгэмжлүүлсэн.

Анхаарах асуудал:

- Эдийн засгийн хичээл цөөн, хөтөлбөрийн нийт кредит 127 байгааг нэмэгдүүлэх
- Өөрийгөө илэрхийлэх чадвараа нэмэгдүүлэх, илтгэх урлагт суралцуулах, гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байх, оюутны холбоотой нягт хамтран ажиллах
- Оюутны оролцоо, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Эдийн засгийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх
- Хичээлийн залгамж, уялдаа холбоог сайруулах, агуулгын давхардлыг арилгах

1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын аргуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэгдсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- БСШУЯ-ны сайдын тушаал 2011, 2014

- ХААИС-ийн захирлын тушаал 2011, 2012, 2014, 2015, 2016, 2017
- Батлагдсан сураглтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө
- “Хичээл эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх” зөвлөмж, ХААИС, СБЗА
- СДИО-ийн гарын авлага
- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Багш нарын өөрийн үнэлгээний тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудтай мэдлэг ур чадвар хэрхэн уялдах уялдааг харуулсан.
- Хөтөлбөрийн шинэчлэлийг оролцогч талуудын оролцоотой тогтмол сайжруулдаг.
- Шинэчлэл хийгдсэн сургалтын төлөвлөгөөг хооронд харьцуулан, дүгнэсэн нь хөтөлбөр хэрхэн сайжирч байгааг харах боломжтой болсон.
- Суралцагчийн сургалтын цагийн ачаалал, хичээл хоорондын уялдаа холбоог гаргаж өгсөн.

Анхаарах асуудал:

- Статистикийн хичээлүүдийн хоорондын уялдаа холбоог илүү дэлгэрэнгүй тайланд тусгах шаардлагатай.
- Сургалтын дадлагыг өөрчилж танилцах дадлага хийлгэх боломж, нөхцөлийг эрэлхийлэх. Бусад хөтөлбөрийн туршлагыг судлах.

Зөвлөмж:

- Эдийн засаг, бизнесийн удирдлагын хичээлийн тоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн агуулгыг шинжлэх ухаан, технологийн дэвшилтэй уялдуулан өөрчлөх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- БСШУЯ-ны сайдын тушаал 2011, 2014
- ХААИС-ийн захирлын тушаал 2011, 2012, 2014, 2015, 2016, 2017
- Батлагдсан сураглтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө

- “Хичээл эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх” зөвлөмж, ХААИС, СБЗА
- CDIO-ийн гарын авлага
- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Багш нарын өөрийн үнэлгээний тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чадамжид суурилсан суралцагчийн идэвхтэй үйл ажиллагааг голлосон, оюутан төвтэй сургалтын арга зүйг ашигладаг.
- Хичээл сонгон суралцах нөхцөл бүрдсэн.
- Сургалтын заах арга болон хичээлийн уялдаа холбоог гаргаж өгсөн нь давуу болсон.
- Багш бүрээр оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг авдаг болсон нь сургалтын үр дүнг сайжруулахад түлхэц болсон.

Анхаарах асуудал:

- Сонгон суралцах хичээлийг тоог нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөрт тусгагдсан хичээл тус бүрийн суралцахуйн үр дүн, сургалтын арга зүйн задаргааг оруулах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ныс сайдын тушаал 2011, 2014
- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ХААИС-ийн захирлын тушаал 2011, 2012, 2014, 2015, 2016, 2017
- Батлагдсан сураглтын төлөвлөгөө 2011, 2015, 2017
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа
- Тэнхимийн хурлын тэмдэглэл 2015-2020
- Хөтөлбөрийн хичээлийн стандарт төлөвлөгөө
- “Хичээл эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх” зөвлөмж, ХААИС, СБЗА
- CDIO-ийн гарын авлага
- ХААИС-ийн оюутны гарын авлага
- ХААИС-ийн багшийн гарын авлага
- Багш нарын өөрийн үнэлгээний тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн хэмжээнд мөрддөг оюутны мэдлэгийн түвшинг үнэлэх стандарт үнэлгээтэй.
- Оюутны мэдлэг чадвар, дадал, хандлагыг үнэлэх онооны бүтэц нь 2015 онд шинчэлэгдсэн бөгөөд тогтвортой ашиглагдаж байна.

Анхаарах асуудал:

- байхгүй

•

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ суралцагчдын оролцоо, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэх

2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лабортори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж бүхий анги танхим, лекцийн заал, лаборатори, цахим сургалтын өрөө, студи, уншлагын танхим болон нийт 3436,6 м² талбай бүхий хичээлийн байртай. Номын сангийн шинэ дөрвөн давхар өргөтгөл баригдаж байна. Багш ажилтан, оюутан суралцагчид ажиллаж, суралцах эрүүл, аюулгүй, тав тухтай орчинг бүрдүүлж чадсан.
- Европын Холбооны ЭРАСМУС ПЛЮС хөтөлбөрийн “Хүнс, ХАА-н салбарын дээд боловсролд цахим сургалтыг нэвтрүүлэх” төслийн хүрээнд “Цахим сургалтын төв” байгуулж цахим хичээлийн материал боловсруулах иж бүрэн тоноглогдсон сургалтын студи, цахим сургалтын тэнхим, цахим уулзалтын өрөө болгон тохижуулснаар цахим сургалтын материалуудыг боловсруулах, шууд дамжуулалт хийх, дотоодын болон олон улсын цахим хурал зөвлөгөөн зохион байгуулах боломжтой болсоноор цахим сургалтын орчинг бүрдүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ дунд гэж үнэлсэн байгааг нягтлан судлаж тэдний санал хүсэлтийг ажилдаа тусгаж хэрэгжүүлэх
- Анги танхимын суудлын хүрэлцээг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Оюутны сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнд тулгуурлан хөтөлбөрийн үр дүнгийн сайжруулалт, хөгжүүлэлтийг хийдэг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- И-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Танхим болон цахимаар сургалт явуулах хичээлийн багц материалтай багш бүртэй уулзаж танилцахад цахим хичээлийн контентийг жигд сайн бэлтгэсэн, хичээл бүр дээр кейс ашигладаг, багш оюутны хоорондын эргэх холбоо сайн зэрэг давуу тал ажиглагдлаа.
- 2020 оны байдлаар хөтөлбөрөөр суралцагчид 3028 үндсэн сурах бичгийг ЭЗБС-ийн номын сангаас авч үйлчлүүлэх боломжтой бөгөөд эдгээрийн 56 хувийг эх хэлээрээ, 44 хувийг гадаад хэлээр ашиглах боломжтой байна.
- Оюутнууд үндсэн сурах бичгийн зэрэгцээ нэмэлт мэдээлэл, материалыг тухайн хичээл орох үед цаасаар болон электрон хэлбэрээр хүлээн авдаг.
- 2015 оноос боловсролын байгууллагад хэрэглэх албан ёсны эрхтэй Google G Suite програмын багцыг хэрэглэдэг бөгөөд хөтөлбөрийн бүх хичээлүүд энэхүү багцын Classroom аппликэйшнд суурилан бусад бүрдэл хэсгүүдтэй хослон 100 хувь цахимаар орох боломжийг бүрдүүлжээ.
- Интернэтийн хүртээмж, хурд сайн.
- Хамтын ажиллагаатай гадаадын их сургууль дээр оюутан дадлага хийх боломжийг бий болгосон.

Анхаарах асуудал:

- Сургалтад ашиглагддаг 17 програм хангамжаас 41 хувь нь зөвшөөрөлгүй байгаад анхаарч зөвшөөрлийг худалдан авах
- Сургалтын удирдлагын мэдээллийн систем хөгжүүлэлтийн талаар тайланд төдийлэн сайн тусгаагүй байна.

Зөвлөмж:

- ХААИС-ийн удирдлагын мэдээллийн системийн дэд бүтцийн хөгжүүлэлтийг шуурхай явуулж сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх
- ХААИС-ийн удирдлагын мэдээллийн системийг ашиглах оюутны гарын авлагыг боловсруулж хэрэглээ болгох

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Тус сургууль олон улсын номын сангийн түвшинд хүрэх зорилгоор нээлттэй-чөлөөт сонголтын үйлчилгээг номын сандаа нэвтрүүлж, хэрэглэгчдэд ойртуулан электрон мэдээллийн санг бий болгож, цахим үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллаж байгаа нь уншигч, хэрэглэгчид орон зай, цаг хугацааны хамааралгүйгээр цахим санг ашиглах боломж нэмэгдэж, номын хүртээмж сайжирч, цаг хугацаа хэмнэх зэрэг ач холбогдолтой үйлчилгээ бий болсон байна.
- Номын санд цөөн хувьтай болон эрэлт ихтэй ном, судалгааны ажлуудыг электрон каталогт оруулан цахимаар унших боломжийг бүрдүүлсэн. 300 гаруй ном, 170 ширхэг судалгааны ажлыг скайнердаж PDF файл болгон "<https://muls.lib4u.net/>" электрон каталогт байршуулсан. Компакт дискээс 332 ш магистрын ажил, 75 ш диссертаци, 135 ш бакалаврын ажлыг хуулж электрон каталогт холбосон. Springer мэдээллийн сангаас англи хэл дээрх 200 ш номыг татан авч электрон каталогт оруулж хэрэглэгчдийн хүртээл болгосон.

Анхаарах асуудал:

- ХААИС –ийн цахим номын сангийн бүртгэлээр тус хөтөлбөрт сүүлийн 5 жилийн дунджаар 4 төрлийн 31 ширхэг ном худалдаж авсан байгаа нь хангалтгүй байна.

Зөвлөмж:

- “Эдийн засаг, статистик” хөтөлбөрт шаардлагатай сүүлийн үеийн сурах бичиг болон бусад нэмэлт материалаар номын сангийн баяжилт хийх санхүүжилтийг нэмэгдүүлж жил бүрийн төсөвт суулгаж номын баяжилт хийдэг болох

3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичиг
- Хамтын ажиллагааны санамж бичгүүд, гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд
- Тэнхимийн жилийн эцсийн тайлангууд
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм журамтай, журмын уялдаа холбоог матрицаар харуулсан.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн шинжилгээг тоон болон чанарын үнэлгээгээр хийдэг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт болон богино хугацааны тайлан төлөвлөгөөг нотлох баримтаар баталгаажуулсан.
- Санал, гомдол хүлээн авч шийдвэрлэх схем нь ойлгомжтой болсон байна.
- Удирдлагын мэдээллийн системийг сургалтын процессод бүрэн ашиглаж байна.

Анхаарах асуудал:

- Удирдлагын бүтцийн зураглалаас харахад сургалтын алба нь сургалтын процессийг тасралтгүй явуулахад дэмжлэг үзүүлдэг дэмжих нэгж. Иймд тэнхимийн дээр зурагдсан байгааг анхаарах хэрэгтэй.
- Хөтөлбөрийн хороо, хамгаалуулах зөвлөл болон шалгалтын комисс нь тэнхимийн доор зурагдсан байгаа нь логик уялдаагүй байна. Учир нь хамгаалуулах зөвлөл болон комисс нь их сургуулийн захирлын тушаалаар батлагддаг түр зөвлөл бөгөөд үйл ажиллагааны хувьд тэнхимд харьяалагдахгүй.

Зөвлөмж:

- Сургалттай холбоотой гарсан санал гомдолыг хэрхэн шийдвэрлэсэн, тухайн санал гомдол ямар үр дүн, үр дагавар, үр нөлөө үзүүлсэн талаар тайланд илүү дэлгэрэнгүй оруулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичиг
- Хамтын ажиллагааны санамж бичгүүд, гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд
- Тэнхимийн жилийн эцсийн тайлангууд
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2015 оноос хойших гадаад, дотоод хамтын ажиллагааг нэгтгэн хүснэгтээр харуулж, нотлох баримтаар баталгаажуулсан нь хамтын ажиллагаа хангалттай сайн хөгжсөн болохыг илтгэж байна.
- 2015-2020 онуудад гүйцэтгэсэн төсөл, гэрээт ажлуудаас харахад нийт 70 төсөл, 50 гаруй гэрээт ажил хийсэн нь хангалттай байна.
- Урт болон богино хугацааны сургалтаар багшийн мэргэжил дээшлүүлэх багш, солилцооны хөтөлбөрт хамрагдсан оюутны тоог дэлгэрэнгүй гарсан, нотлох баримтаар баталгаажуулсан нь энэ шаардлагыг хангахаар байна.

Анхаарах асуудал:

- Төсөл гэрээт ажлуудад оюутнуудыг оролцуулдаг байх
- Төгсөгчдөд чиглэсэн давтан сургалтын программ нэвтрүүлэх

Зөвлөмж:

- Богино хугацааны сургалт явуулдаг байх, давтан сургах боломжийг бүрдүүлэх замаар төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах
- Хийгдсэн судалгааны ажлуудыг нийгэмд түгээн дэлгэрүүлэхэд анхаарах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичиг
- Хамтын ажиллагааны санамж бичгүүд, гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам

- ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд
- Тэнхимийн жилийн эцсийн тайлангууд
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн нийт орлого болон зардлын задаргааг дэлгэрэнгүй харуулсан.
- Нэг оюутанд ногдох сургалтын шууд болон шууд бус зардлын задаргааг сүүлийн таван жилээр хийсэн.

Анхаарах асуудал:

- Дахин сонголтын орлого буурахгүй байгаа шалтгааныг олж тогтоох, бууруулахад анхааран ажиллах
- Сургалтын төлбөрийн орлогыг оюутны тооноос хамааруулан графикаар үзүүлэх
- Сүүлийн хоёр жилд ашигтай ажилласан боловч эрдэм шинжилгээ судалгааны ажлын болон багшийн мэргэжил дээшлүүлэх зардал болон нэг оюутнад ноогдох хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь учир дутагдалтай байна.
- Сургуулийн хэмжээнд орлогод суурилсан зардлын тогтолцоог бий болгон орлогыг шударга хуваарилахад анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Нийт зардалд эзлэх багшийн мэргэжил дээшлүүлэх, судалгаа болон эрдэм шинжилгээний ажил хийхтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх
- Сургуулийн хэмжээнд орлогод суурилсан зардлын тогтолцоог бий болгох
- Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ҮСХ-оос ирүүлсэн албан бичиг
- Хамтын ажиллагааны санамж бичгүүд, гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд
- Тэнхимийн жилийн эцсийн тайлангууд
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Эдийн засаг, статистик” бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- ЕБС төгсөгчдийн мэргэжлийн сонголт, мэргэжлийн чиглэл олгох “ХААИС-ийн маркетингийн идэвхжүүлэлтийн хөлбөр”-ийг 2015 оноос хойш хэрэгжүүлэн ажиллаж байна.
- “Мэргэжил миний ирээдүй”, “Элсэлтийн нээлттэй мэдээлэл”, “ХААИС-ийн элч оюутан” гэх мэт хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг.
- Элсэгчдэд зориулан богино хэмжээний видео хийн цахим хуудсаараа дамжуулан түгээдэг.

Анхаарах асуудал:

- “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийг мэргэжил сурталчлах замаар нийгэмд түгээн дэлгэрүүлэхэд анхаарах
- ХААИС-ийн идэвхжүүлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн сургууль, тэнхим хэрхэн идэвхтэй, санаачилгатай оролцсон талаар тайланд дэлгэрэнгүй оруулах

Зөвлөмж:

- Сургууль, тэнхим хөтөлбөрийн талаарх мэдээллийг нийгэмд түгээн дэлгэрүүлэх идэвхжүүлэлтийн хөтөлбөртэй болох
- Хөтөлбөрийн хүрээнд уламжлал болгон хэрэгжүүлдэг нийгэмд чиглэсэн арга хэмжээтэй болох

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- ҮСХ-оос ирүүлсэн албан бичиг
- Хамтын ажиллагааны санамж бичгүүд, гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2020 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Багшийн өөрийн үнэлгээний тайлангууд
- Тэнхимийн жилийн эцсийн тайлангууд
- Багшийн хавтас

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл, танилцуулга, багш оюутны эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, оюутны гарын авлага, ЭЗБС-ийн элсэгчдэд

зориулсан гарын авлага, видео танилцуулга, веб хуудсаар дамжуулан хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангадаг

- Хөтөлбөрийн талаарх нийтэд цацагдсан мэдээллийн давтамжийн судалгааг хийсэн
- Веб хуудас нь тогтмол ажиллагаатай

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг нийтэд түгээхэд бодлогоор дэмжих

Зөвлөмж:

- Мэдээллийн технологийн нээлттэй ил тод байдлыг хангах, нийтэд түгээхэд түлхүү ашиглах

4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн веб хуудас
- Элсэгчийн цахим бүртгэлийн холбоос
- Шинэ элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага
- ХААИС-ийн оюутны суралцах гэрээ
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн СБЗА-аас эрхлэн гаргадаг шинээр элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага нь 4 бүлэгтэй, сургалтын төлөвлөгөө, сургалттай холбоотой дүрэм журам, оюутанд үзүүлэх үйлчилгээ, спортын секц дугуйлан, сайн дурын клубүүдийн мэдээлэлийг багтаасан байдаг.
- Оюутнуудад цахим хэлбэрээр мэдээлэл зөвлөгөө өгөх веб хуудас ажиллуулдаг. Үүгээрээ дамжуулан хурдан шуурхай мэдээлэл хүргэдэг.
- Энэ хөтөлбөрөөр элсэгчидийн ЭЕШ-ын дундаж оноо нь ЭЗБС-ийн нийт элсэгчдийн дундаж онооноос 26 оноогоор илүү байна.
- Элсэн орохдоо мэргэжлээ сонгон, суралцдаг болсон.
- АНУ-ын Перегрины Академитай хамтран 2014-2019 онуудад элсэгч болон төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг үнэлүүлсэн.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны хөгжил төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн төлөвлөгөө, тайлан
- Шинэ элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага
- ХААИС-ийг 2016-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, Хаан кампус хөтөлбөр
- “ХААИС-ийн Оюутны хөгжил хөтөлбөр” бодлогын баримт бичиг, 2019 он
- ХААИС-ийн оюутны байрны дотоод журам
- ХААИС-ийн оюутны суралцах гэрээ
- Зөвлөх багшийн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө болон багшийн ажлын дэвтэр
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС нь оюутан суралцагчдын бие даан хөгжих, амьдрах, суралцах таатай орчныг бүрдүүлэх үүднээс “Оюутны хөгжил хөтөлбөр”, “Хаан кампус” хотхон, “Экологийн цэвэр орчин”, “Гэрэлтүүлэг-1” зэрэг дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- Оюутны хөгжлийн төв, Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй.
- Суралцагч оюутанд үйлчилгээ үзүүлэх алба нэгжүүд нь “Чанартай сургалт-сэтгэл ханамжтай оюутан” гэсэн уриа дор сургалтын үйлчилгээ, нийгмийн үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, зөвлөгөө өгөх үйлчилгээ, хувь хүний төлөвшил, хөгжлийг дэмжих үйлчилгээ, мэдээ мэдээллийн үйлчилгээ зэрэг 6 чиглэлээр 23 төрлийн үйлчилгээг тогтмол үзүүлдэг. /ӨҮТ, 88-р тал, Зураг 5.3/
- Гадаад хамтын ажиллагаатай сургуульд оюутнуудаа сургалтын дадлага хийлгэдэг. Сүүлийн 5 жилд 20 оюутан Япон, БНУУ, ОХУ, БНХАУ зэрэг орнуудын хамтын ажиллагаатай сургуульд сургалтын дадлага, танилцах дадлага хийсэн байна. /ӨҮТ, 94-р тал, Хүснэгт 5.2/

Анхаарах асуудал:

- Оюутны хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг үнэлдэг байх
- Оюутны эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай

Зөвлөмж:

- Оюутны эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний норм норматив, стандартыг судлах, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд эмчтэй болох

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны хөгжил төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн төлөвлөгөө, тайлан
- Нийслэлийн хөдөлмөрийн газрын “Оюутан, суралцагчдыг цагийн ажилд зуучлах журам”
- Шинэ элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага
- ХААИС-ийг 2016-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, Хаан кампус хөтөлбөр
- “ХААИС-ийн Оюутны хөгжил хөтөлбөр” бодлогын баримт бичиг, 2019 он
- ХААИС-ийн оюутны суралцах гэрээ
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам /Оюутны урамшуулал, 7-р бүлэг/
- Зөвлөх багшийн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө болон багшийн ажлын дэвтэр
- ХААИС-ийн оюутны хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн цахим хуудас
- Оюутны сэтгэл ханамжийн судалгаа
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн хэмжээнд нийт 31 оюутны клуб байдаг.
- Оюутнууд хичээлийн бус цагаар цагийн ажил эрхлэх боломжтой.
- ХААИС-ийн Оюутны холбоо нь сайн дурын олон талт үйл ажиллагаа зохион байгуулах, оюутнуудын оролцоог хангахад ихээхэн анхаардаг. ЭЗБС нь Оюутны зөвлөлтэй.
- Сайн дурын ажилд оролцсон оюутнуудыг ЭЗБС-ийн зарлалын телевиз, вэб хуудас, тэнхимийн мэдээллийн самбарт мэдээ гаргах замаар сурталчилдаг.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс 2016-2020 оны хооронд давхардсан тоогоор 180 лекц, сургалт, өдөрлөг зохион байгуулсан. /ӨҮТ, 97-р тал, Хүснэгт 5.5/
- Хөтөлбөрийн оюутнууд ҮСХ-ны Аж ахуйн нэгжийн тооллого, Хүн ам орон сууцны тооллого, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа зэрэгт оролцож дадлага хийхийн зэрэгцээ цалинждаг байна.

Анхаарах асуудал:

- Оюутны клуб багшаас хамааралгүй, бие даасан байхад анхаарах
- Хөтөлбөрийн оюутнууд хамрагддаг клубын тоо цөөн /ӨҮТ, 95-р тал, Хүснэгт 5.3/
- Сайн дурын ажилд оюутнуудын жигд оролцоог хангах, идэвхийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Оюутны байгууллага, клубын үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжих, төсөвт тодорхой санхүүжилт тусгах, зарцуулалтыг хянах, тайлагнах механизмыг бүрдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн бакалаврын сургалт үйл ажиллагааг зохицуулах журам, 5.2.3
- Оюутны шилжилт хөдөлгөөний тайлан, мэдээ
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг зохицуулах журамтай. Тухайлбал, ХААИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 5-д заасныг баримталдаг.
- Гадаад, дотоодын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиудаас өөрийн хүсэлтээр оюутан шилжин суралцдаг. Энэ тохиолдолд шилжин ирэх оюутны ЭЕШ-ын чиглэл тохирсон, дүйцүүлэлтийн нийт кредит зөрүү 12-оос ихгүй, элссэнээс хойш 1 улирал суралцсан, 2-оос доошгүй үнэлгээний голчтой байх гэсэн шаардлагыг тавьдаг. Төгсөх ангид оюутан шилжүүлэн суралцуулахыг хориглодог.

Анхаарах асуудал:

- Шилжилт хөдөлгөөний болон сургуулиас гарсан шалтгааныг тодруулах
- ӨҮТ-нд сүүлийн 5 жилд 61 оюутан гарсан гэсэн тоон мэдээ нь алдаатай бичигдсэн байх тул залруулах шаардлагатай. /ӨҮТ, 100-р тал/

Зөвлөмж:

- Байхгүй

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны Дээд боловсролын диплом олгох журам
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн тайлан, мэдээ
- “Эдийн засаг, статистик” хөтөлбөрийн төгсөх оюутны дипломын ажлын сэдэв, удирдагч, дипломын ажил хамгаалах хугацааг тогтоосон тушаал
- Төгсөлтийн шалгалт өгөх оюутны нэрсийг батлах тухай тушаал
- Төгсөлтийн салбар комисс батлах тухай тушаал
- Бакалаврын зэрэг олгох дипломын төсөл хамгаалуулсан шийдвэр
- Төгсөлтийн салбар комиссын хурлын тогтоол
- Төгсөгчдийн боловсролын бичиг баримт олгосон тухай нэгдсэн бүртгэл
- Төгссөн оюутны диплом, хавсралтын эх загвар

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Диплом шалгах программтай.
- Төгсөлтийг жилд 2 удаа зохион байгуулдаг.
- Голч онооны шаардлага хангасан төгсөгчдөд улаан диплом олгодог.

Анхаарах асуудал:

- байхгүй
-

Зөвлөмж:

- байхгүй

5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
- ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам
- ХААИС-ийн Профессорын багийн ажиллах журам
- ХААИС-ийн багшийн мэргэжлийн ёс зүйн дүрэм
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Багшийн хөгжил хөтөлбөр
- ХААИС, ЭЗБС-ийг хөгжүүлэх бодлогын баримт бичиг
- Багшийн хавтас, хөдөлмөрийн гэрээ
- ХААИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан Хамтын гэрээ
- Багш нарын шагналын судалгаа
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим нь 2015 оноос хойш шинээр багш сонгон шалгаруулж аваагүй. Багшлах бүрэлдэхүүний хувьд тогтвор суурьшилтай ажилладаг. Багш нар

бүгдээрээ 10-аас дээш жилийн ажлын туршлагатай. Багш нарын 50% нь доктор /PhD/ зэрэгтэй

- Зөвлөх профессор, зочин профессор, гэрээт багш ажиллуулах нөхцөл боломж, эрх зүйн баримт бичгүүд бүрдсэн.
- Богино улирлын системээр сургалт явагддаг. Оюутны хичээл сонголт болон хичээл заалгах багшийн сонголт чөлөөт системтэй.
- Нэг багшид ногдох оюутны тоо 17 ба багш нар судалгаа, эрдэм шинжилгээни Б цагийн нормоо давуулан биелүүлдэг.

Анхаарах асуудал:

- Багшийн зэрэглэл, урамшуулалтай холбоотой сэтгэл ханамжийн судалгаа хийх
- Багш бүр хөтөлбөрийн эрхэм зорилгоо мэддэг, түүн рүү чиглэж ажилладаг, оюутандаа эрхэм зорилгыг тайлбарлаж, таниулдаг соёлыг бий болгоход анхаарах

Зөвлөмж:

- байхгүй

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Багшийн хөгжил хөтөлбөр
- Багшийн хөгжил хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээ
- Тэнхимийн өөрийн үнэлгээний тайлан, мэдээ
- Багшийн хавтас
- Цахим хичээлийн бүрдэл, цахим сургалтын үйл явцтай танилцсан бодит байдал
- Багш нарын шагналын судалгаа
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын 50% нь доктор /PhD/ зэрэгтэй, үлдсэн багш нар нь бүгд докторантурт суралцаж байгаа.
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2019-2028 он, ЭЗБС-ийг 2011-2020 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөөнд багшийн хөгжлийн асуудал тусгагдсанаас гадна “Багшийн хөгжил” хөтөлбөр хэрэгжүүлдэг.
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журмын дагуу үнэлж хувь хүний ахиц дэвшил, тухайн багшийн хөгжлийн түвшинг тогтоодог.
- Багшийн чадамжийн үнэлгээний нэгдсэн мэдээллийн сантай.

- Сүүлийн 5 жил давхардсан тоогоор жилд дунджаар 11 багш гадаад, дотоодод богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан. /ӨYT, 112-р тал, Хүснэгт 6.7/

Анхаарах асуудал:

- Багшийн жилийн ажлын төлөвлөгөөнд багшийн хөгжлийн асуудал тусгагддаг буюу 1 жилээр төлөвлөгдөж байгаа нь учир дутагдалтай байна.
- Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтэд анхаарах

Зөвлөмж:

- Багш бүр өөрийн багшийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, явц үр дүнгээ өөрөө үнэлдэг соёлыг бий болгох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын Дээд боловсролын тухай хууль
- Монгол улсын Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Багшийн хөгжил хөтөлбөр
- Багшийн хөгжил хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээ
- Тэнхимийн өөрийн үнэлгээний тайлан, мэдээ
- Багшийн хавтас
- Багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлүүд
- Багш нарын туурвисан ном, сурах бичиг, гарын авлага
- Багш нарын оролцсон төсөл, хөтөлбөрийн жагсаалт / ӨYT, 114-р тал/
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар туурвисан бүтээлээ зохиогчийн гэрчилгээгээр баталгаажуулдаг. Сүүлийн 5 жилд 4 багш 6 зохиогчийн гэрчилгээ авсан.
- Тэнхимийн багш нар сүүлийн 5 жилд нийт 118 олон улсын төсөл, дотоодын гэрээт, захиалгат ажил болон сургалт, семинарыг зохион байгуулахад оролцсон. /ӨYT, 113-р тал, Хүснэгт 6.10/
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нарын 50% нь доктор /PhD/ зэрэгтэй.
- Богино улирлын систем нь багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- Хүлээн зөвшөөрөгдсөн ISBN дугаартай сэтгүүл, олон улсын нэр хүндтэй сэтгүүлд тус тус өгүүлэл хэвлүүлэх, эшлэл татагдсан байдлыг харгалзан ХААИС-ийн Захирлын А/168 тоот тушаалын дагуу урамшуулал олгодог.

Анхаарах асуудал:

- Тэнхмүүдэд тусгайлсан төсөв баталдаггүй.

Зөвлөмж:

- Багш нарын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардлын төсвийг нэмэгдүүлэх

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, Багшийн хөгжил хөтөлбөр
- Багшийн хөгжил хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, мэдээ
- Тэнхимийн өөрийн үнэлгээний тайлан, мэдээ
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хавтас
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааны тайлан, мэдээ
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан, мэдээ
- Багш нартай хийсэн уулзалт, ярилцлага
- Суралцагч ба төгсөгчидтэй хийсэн уулзалт, ярилцлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийдэг.
- Оюутны сэтгэл ханамжийн 1-5 баллаар үнэлгээ бүхий судалгаагаар багшийн мэргэжлийн мэдлэг, багшийн ур чадвар, багшид өгөх сэтгэл ханамж, багшийн нэр хүнд гэсэн үзүүлэлтүүд сүүлийн 3 хичээлийн жил дараалан 4-ээс дээш үнэлгээтэй гарсан.
- Багшийн хөндлөнгийн үнэлгээг тооцоход ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журмын 4-ийг баримталдаг ба нийт 100%-ийн үнэлгээнд салбар зөвлөлөөс өгөх үнэлгээ 80%, оюутны үнэлгээ 10%, хамт олны үнэлгээ 5%, бүрэлдэхүүн сургуулийн удирдлага 5%-ийг эзэлдэг байна.

Анхаарах асуудал:

- Багшийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний харьцуулсан судалгаа хийгддэггүй
- Судалгааны үр дүнд суурилсан багшийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн мөшгөх үйл ажиллагаа хийгддэггүй

Зөвлөмж:

- Суралцагчид болон төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд үндэслэн багшийн үнэлгээг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, улмаар тасралтгүй сайжруулалт, хөгжүүлэлтийг хийдэг хэвшмэл үйл ажиллагааг бий болгох

6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах тухай тушаал
- “Мэргэжлийн хөтөлбөрүүдийн чанарын дотоод баталгаажуулалтад мөрдөх журам”
- Эдийн засаг, статистик мэргэжлийн хөтөлбөрийн хороог байгуулсан ЭЗБС-ийн захирлын 2016 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/45. тоот тушаал
- Мэргэжлийн хөтөлбөрийн хороо нь сүүлийн 5 жилийн хугацаанд 5 удаа хуралдаж, төгсөгчтэй 3 удаа, ажил олгогч, мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй 3 удаа уулзалт хэлэлцүүлэг хийсэн хурлын тэмдэглэл
- ХААИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээний журам (ХААИС-ийн захирлын 2015.06.23- ны өдрийн А/211 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан)
- ХААИС-ийн Дотоод аудитын журам (ХААИС-ийн захирлын 2015.06.23-ны өдрийн А/211 тоот тушаалын 2-р хавсралтаар батлагдсан)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн захирлын 2018 оны Б/283 тоот тушаалаар сургуулийн захиргааны бүтцэд Чанарын удирдлага, зохицуулалтын алба гэсэн бие даасан нэгжийг байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь жигдэрч тогтмолжсон давуу талтай. ХААИС-ийн чанарын менежментийн тогтолцоо нь сургалт, судалгааны ажлыг дүгнэж, эрхэм зорилгодоо хүрэх стратегийн бодлогын хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийж, тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг тогтмол явуулж олон улсад чанарын менежментийн тогтолцоог PCDA зарчмаар хэрэгжүүлж ирсэн нь хөтөлбөрийн чанарыг сайжруулахад зохих үр дүнг өгсөн байна. 2017 оноос DMAIC (зургаан сигма) аргачлалыг хэрэгжүүлэх эхний алхмуудыг туршиж эхлэсэн.
- Хөтөлбөрийн оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад төгсөгч - 3.71; ажил олгогч - 4.09 байгаа нь тус хөтөлбөрт оролцогч талууд сэтгэл ханамжтай байгааг харуулж байна.
- Мэргэжлийн хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хийдэг бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд төгсөгчтэй 3 удаа, ажил олгогч, мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй 3 удаа уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан нь хөндлөнгийн баталгаажуулалтын механизмын илрэл гэж үзэж болно.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажилагаанд оролцогч талуудын ажлын төлөвлөлтөнд чанарын мөчлөгийг нэвтрүүлж хэвшихэд анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, алба нэгжийн ажил үүргийн уялдаа холбоог илүү сайжруулах, процессийн зураглал хийх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн үр дүнг төгсөгчдийн ажил эрхлэлт, карьер өсөлт, ажилд орох хүртэлх хугацаа, ажил олгогчийн сэтгэл ханамж зэрэг судалгааны үр дүнг үндэслэн дүгнэдэг байна.
- Мэргэжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, өөрчлөн сайжруулахад хөтөлбөрийн оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнг харгалзан үздэг.

Анхаарах асуудал:

- Суралцагч буюу төгсөгчийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарах
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн тогтвортой байдлын судалгааг хийх
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд суурилсан мөшгөх үйл ажиллагааг тогтмолжуулах, хэвшүүлэх

Зөвлөмж:

- байхгүй

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь
- Дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Эдийн засаг, статистик” хөтөлбөр ACSBP олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар 2014 онд магадлан итгэмжлэгдсэн.
- Тус байгууллагаас нийт 8 дэд шалгуур үзүүлэлтийг сайжруулах зөвлөмжийг өгч байсан байна. Үүний дагуу тухайн ажлуудыг сайжруулан хийж 2016, 2018 онуудад ахиц дэвшлийн тайланг ACBSP байгууллагад хүргүүлсэн.
- 2016-2020 оны төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаанаас харахад ҮСХ болон нийслэл, аймаг, дүүргийн статистикийн алба, хэлтсүүдэд болон тө бусад төрийн болон хувийн байгууллагуудад статистикч, хяналт-шинжилгээ-үнэлгээний мэргэжилтнээр төгсөгчид тус тус ажиллаж байна.
- Мэргэжлийн холбоод болон бусад байгууллагуудтай идэвхитэй хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- байхгүй

Зөвлөмж:

- байхгүй

7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн Эдийн засаг, статистик бакалаврын сургалтын хөтөлбөр

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан/хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	2			
6	Багшлах бүрэлдэхүүн	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	2			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС-ийн ЭЗБС-ийн “Эдийн засаг, статистик /D031103/” бакалаврын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг Ч.Наранчимэг

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... М.Должин

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... М.Банзрагч

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Сургуулийн нэр	ХААИС, ЭЗБС
Хөтөлбөрийн нэр	Эдийн засаг, статистик
Хөтөлбөрийн индекс	D031103
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Эдийн засгийн хичээлийн цагийг нэмэгдүүлэх • Хичээлийн залгамж, уялдаа холбоог сайжруулах, агуулгын давхардлыг арилгах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ суралцагчдын оролцоо, бүтээлч хамтын ажиллагааг өргөжүүлэх • PLO, CLO-г хөтөлбөрт илүү нарийвчилж тусгах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	<ul style="list-style-type: none"> • ХААИС-ийн удирдлагын мэдээллийн системийн дэд бүтцийн хөгжүүлэлтийг шуурхай явуулж, сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх • ХААИС-ийн удирдлагын мэдээллийн системийг ашиглах оюутны гарын авлагыг боловсруулж, хэрэглээ болгох • “Эдийн засаг, статистик” хөтөлбөрт шаардлагатай сүүлийн үеийн сурах бичиг болон бусад нэмэлт материалаар номын сангийн баяжилт хийх санхүүжилтийг нэмэгдүүлж, жил бүрийн төсөвт суулгаж, номын баяжилт хийдэг болох
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийн схемийг сайжруулах • Оюутнуудыг ҮСХ-оос гадна бусад байгууллагын хамтарсан судалгаанд оролцуулдаг байх, оролцоог нэмэгдүүлэх
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> • Оюутны эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор сургуулийн эрүүл мэндийн үйлчилгээний норм норматив, стандартыг судлах, бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд эмчтэй болох • Оюутны байгууллага, клубын үйл ажиллагааг санхүүгийн хувьд дэмжих, төсөвт тодорхой санхүүжилт тусгах, зарцуулалтыг хянах, тайлагнах механизмыг бүрдүүлэх
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Багш бүр өөрийн багшийн хөгжлийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, явц үр дүнгээ өөрөө үнэлдэг соёлыг бий болгох • Багш нарын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардлын төсвийг нэмэгдүүлэх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> • Хөтөлбөрийн чанарыг сайжруулах стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх, алба нэгжийн ажил үүргийн уялдаа холбоог илүү сайжруулах, процессийн зураглал хийх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаалын зэрэглэл	Эрдмийн зэрэг	Ажилласан жил		Заадаг хичээл
				Улсад	Тэнхимд	
1	П. Мөнхтуяа	Тэнхимийн эрхлэгч	PhD	17	17	<ul style="list-style-type: none"> Хүн ам, нийгмийн статистик
2	М. Эрдэнэбаяр	Дэд профессор	PhD	23	23	<ul style="list-style-type: none"> Үндэсний тооцооны систем, салбар хоорондын балансын шинжилгээ
3	Д. Цэвээннамжил	Ахлах багш	PhD	21	9	<ul style="list-style-type: none"> Магадлалын онол Математик статистик I,II Статистикийн онол I,II
4	Г. Буманжаргал	Ахлах багш	PhD	13	9	<ul style="list-style-type: none"> Эконометрик I Санхүүгийн статистик Статистикийн онол
5	Г. Золзаяа	Ахлах багш	PhD	13	10	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн прогнозчлол Эдийн засгийн статистик
6	Я. Эрдэнэсүрэн	Ахлах багш	M.Sc	23	13	<ul style="list-style-type: none"> Статистикийн онол Эконометрик I,II
7	Ш. Баярдулам	Ахлах багш	M.Sc	16	16	<ul style="list-style-type: none"> Статистикийн онол Эдийн засгийн статистик Худалдаа, үйлчилгээний статистик
8	Ч. Батжаргал	Багш	M.Sc	26	8	<ul style="list-style-type: none"> Статистикийн онол Эдийн засгийн статистик Статистик мэдээлэл боловсруулалт
9	Г. Энх-Амгалан	Багш	M.Sc	14	14	<ul style="list-style-type: none"> Хөдөө аж ахуйн статистик Эдийн засгийн статистик II Эконометрик
10	Г. Түмэндэмбэрэл	Багш	M.Sc	11	11	<ul style="list-style-type: none"> Эдийн засгийн статистик Эконометрик I,II

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Б.Азжаргал	1	Орон нутаг
2	М.Азжаргал	4	Голч дүн
3	Б.Ану	3	Голч дүн
4	Т.Алтанхуяг	3	Багануур дүүрэг
5	Г.Ануужин	3	УБ хот
6	Т.Баттүшиг	4	Голч дүн
7	Б.Даваажаргал	1	УБ хот
8	Б.Лхагважавхлан	2	Голч дүн
9	Д.Мөнхбилэг	4	УБ хот
10	С.Мөнх-Эрдэнэ	4	Орон нутаг
11	М.Мөнхзул	4	Орон нутаг
12	Б.Отгонтуяа	4	УБ хот
13	Г.Отгонтуяа	3	Голч дүн
14	Х.Түмэнцэцэг	3	Голч дүн
15	Ш.Хонгорзул	4	Орон нутаг
16	Г.Чулуунчимэг	2	Оюутны байр
17	А.Шийрав	4	УБ хот
18	Ч.Шинэбилэг	3	Багануур дүүрэг
19	Г.Энхтөр	2	Орон нутаг
20	Г.Юмжирдулам	3	Голч дүн

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Б.Насан	ИЗИС	Санхүү, эдийн засгийн сургуулийн захирал
2	А. Дэмбэрэл	ҮСХ	Шинжилгээ, судалгааны газрын дарга
3	Ж.Эрдэнэбилэг	“SICA” судалгааны компани	Гүйцэтгэх захирал
4	Б.Энхтуяа	Дундговь аймгийн статистикийн хэлтэс	Хэлтсийн дарга
5	Ш.Ундармаа	Максимус Дистрибьюшн ХХ	Хүний нөөцийн менежер
6	Батмөнх	Төрийн банк	Салбарын захирал
7	Э.Хосбаяр	Хос финанс ББСБ	Захирал
8	Оюунболор	Номин Холдинг ХХК	Хүний нөөцийн менежер
9	Д.Ангар	Novel Group LLC	Дарга
10	Б.Баасансүх	ХААИС, ЭЗБС	Захирал
11	Н.Эрлан	Баян-Өлгий аймгийн статистикийн хэлтэс	Хэлтсийн дарга
12	Мэндсайхан	Стийл Энд Конкрийт ХХК	Захирал
13	А.Болормаа	Улсын 3-р төв эмнэлэг	Статистикч эмч

14	Н.Гансүх	Асралт мед эмнэлэг	Эмнэлгийн дарга
15	Д.Одгэрэл	ЧД ХХҮХэлтэс	ХЭА-ны дарга
16	А.Заяхүү	Нийслэлийн статистикийн хэлтэс	НСГ-ын дарга
17	Ж.Батцэнгэл	Завхан аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Хэлтсийн дарга
18	Ц.Энхтуул	Өмнөговь аймгийн ЗДТГ-ын санхүүгийн хяналт, аудитын алба	Албаны дарга
19	Г.Хурцбилэг	Дархан-Уул аймаг Аймгийн Засаг Даргын Дэргэдэх Статистикийн Хэлтэс	Хэлтсийн дарга
20	С.Оргилмаа	УБ цахилгаан түгээх	Ерөнхий нягтлан бодогч
21	С.Бямбабаатар	Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс	Хэлтсийн дарга
22	Н.Нэргүй	Өмнөговь аймагт, Оюунтолгой салбар ХААН банк	Эрхлэгч

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Д.Элбэгзаяа	2005	ИЗИС	Багш
2	Ц.Онон	2005	УБТЗ Багануур өртөө	Ерөнхий нягтлан бодогч
3	Э.Гантуяа	2006	ҮСХ	Ахлах статистикч
4	Л.Мөнхсайхан	2006	ХААН банк	Салбарын захирал
5	А.Ганчимэг	2006	Монголын худалдааг дэмжих ОУ-ын төсөл	Төслийн нягтлан бодогч
6	Х.Долгормаа	2007	"SICA" судалгааны компани	Ахлах судлаач
7	А.Батцэцэг	2008	ХААН банк	Зээлийн эдийн засагч
8	С.Доржханд	2008	Дундговь аймгийн статистикийн хэлтэс	Мэргэжилтэн
9	Э.Энхцэцэг	2011	Максимус Дистрибьюшн ХХ	Ахлах нягтлан бодогч
10	Б.Жавзандулам	2011	Төрийн банк	Хянан шалгагч
11	Г.Ган-Эрдэнэ	2011	Хос финанс ББСБ	Эдийн засагч
12	Т.Үржинбадам	2011	Номин Холдинг ХХК	Эдийн засагч, төслийн менежер
13	Б.Буянжаргал	2011	Novel Group LLC	Захирал
14	С.Лхагвадорж	2011	Төрийн банк	Салбарын захирал

15	А.Энхжаргал	2012	ХААИС, ЭЗБС	Сургалтын менежер
17	А.Чанцалдулам	2015	Набсан ХХК	Нярав
18	С.Оюунсүвд	2015	Стийл Энд Конкрыйт ХХК	Эдийн засагч
19	Д.Бадамцэцэг	2015	Анунгоо ХХК	Худалдааны төлөөлөгч
20	Ч.Долгорсүрэн	2016	Кредит банк	Аудитор
21	Б.Батаа	2016	Увс, Голомт банк	VIP теллер
22	Б.Гарамгай	2016	Улсын 3-р төв эмнэлэг	Статистик мэдээллийн ажилтан
23	Н.Сувд-Эрдэнэ	2016	Асралт мед эмнэлэг	ЭМД, Статистикч
24	Б.Лхагвадулам	2016	Хил хамгаалах ерөнхий газар	Эдийн засаг, төлөвлөлтийн мэргэжилтэн
25	Ч.Чанцалдулам	2016	DDT ХХК	Менежер
26	А.Мөнхшүр	2016	ЧД ХХҮХэлтэс	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
27	Ч.Бүжинлхам	2017	Нийслэлийн статистикийн хэлтэс	Мэргэжилтэн
28	Б.Сайнбилэг	2017	БШУЯ	Дэд сайдын туслах бөгөөд гамшгаас хамгаалах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
29	Ж.Лхагвасүрэн	2017	Завхан аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	Мэргэжилтэн
30	О.Чинбат	2017	Өмнөговь аймгийн ЗДТГ-ын санхүүгийн хяналт, аудитын алба	Дотоод аудитор
31	И.Цэцгээ	2017	"Өгөөж Найрамдал" ХХК	Зээлийн мэргэжилтэн
32	Ж.Мөнхтуяа	2018	Дархан-Уул аймаг Аймгийн Засаг Даргын Дэргэдэх Статистикийн Хэлтэс	Зохион байгуулагч
33	Э.Шаравдорж	2018	УБ цахилгаан түгээх	Нярав
34	Б.Билэгжаргал	2018	УБ, БГД, Хаан банк	Борлуулалт үйлчилгээний ажилтан
35	А.Тамир	2018	Голомт банк	Теллер

36	Н.Билгүүн	2018	Төрийн банк	Теллер
37	Н.Нандин-Эрдэнэ	2019	Монгол даатгал, Өвөрхангайн салбар	Менежер
38	ЦЦолмонзаяа	2019	Жендерийн үндэсний хороо	Мэргэжилтэн
39	М.Баянмөнх	2019	Өмнөговь аймагт, Оюунтолгой салбар ХААН банк	Зээлийн эдийн засагч
40	Ч.Нямбаяр	2019	Дундговь аймаг, Өлзийт сум, татварын алба	Байцаагч
41	А.Гантөмөр	2019	УБ, Төрийн банк	Теллер
47	Б.Цэцэгнавч	2021	Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс	Мэргэжилтэн

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/